
Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалт сайжруулах үйл ажиллагааны танилцуулга

Д.Пүрэвдорж[1], Д.Алтансоёмбо[2], О.Тэмүүлэн[3], Д.Ууганзаяа[4], Д.Нямсүрэн[4], Г.Мөнхтулга[5], Э.Хишигбаатар[5], О.Ичинноров[5], Б.Тэмүүжин[6]


[1]Дүрс оношилгоо, Компьютер томограф алба, Тоног Төхөөрөмж Ашиглалтын алба, УХТЭ
[2]Мэс засал I, II-р тасаг, ТТАА, УХТЭ
[3]Эрчимт эмчилгээ, ТТАА, УХТЭ
[4]Мэдрэл, Хоол боловсруулах эрхтэн, Зүрх судас судлал, Тусгай тасаг, Амбулатори, ТТАА, УХТЭ
[5]Нэгдсэн лаборатори, ТТАА, УХТЭ
[6]Кислород, Ариутгал, Угаалга, Сэргээн засах, Эмийн сан, ТТАА, УХТЭ

Түлхүүр үг: Эмнэлгийн тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн ашиглалт сайжруулах

Товч утга: Манай албаны үйл ажиллагаа нь тус эмнэлэгт ашиглагдаж байгаа оношилгоо, эмчилгээ, лабораторийн эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн үйлдвэрийг найдвартай тасралтгүй ажиллагаагаар нь хангахад чиглэгддэг. УХТЭ-т 2020 оны хагас жилийн байдлаар 152 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж 721ш, 22 нэр төрлийн эмнэлгийн бус тоног төхөөрөмж 110ш, Багаж хэрэгсэл 8000 ш гаруй ашиглагдаж байна.



Зураг 1. Тоног төхөөрөмжийн ангилал



Зураг 2. Тоног төхөөрөмжийн насжилтаар

Үйл ажиллагааны чиглэл:

• Тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт:

1. Шинээр нийлүүлэгдсэн болон байршил солигдсон тоног төхөөмжүүдийг угсарч суурилуулах ажлыг нийлүүлэгч байгууллагатай хамтран болон бие даан хийж гүйцэтгэх,
2. Аппаратын үйл ажиллагааг нь эхлүүлэн ашиглалтын талаар сургалт хийх.



• Техникийн үзлэг үйлчилгээ

1. Тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, найдвартай хэвийн ажиллагааг хангах
2. Графикт болон өдөр тутмын техник үйлчилгээг хийх.
3. Тоног төхөөмж ашиглагчдын үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө өгөх



• Их ба урсгал засвар

1. Тухайн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөлд заагдсан хугацаатай болон хугацаагүй сэлбэг хэрэгслийг захиалан авч солих,
2. Эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллагаанд оруулах



• Сургалт
1. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд тоног төхөөрмжийн ашиглалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах
2. Шинээр ажилд орсон ажилтнуудад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны анхан шатны зааварчилгаа өгөх сургалтыг тус тус зохион байгуулдаг.




• Бичиг баримтын бүрдэл, хөтлөлт хийх
1. Тоног төхөөрөмж бүрийг Техник ашиглалтын паспортжуулах, түүний хөтлөлт баяжилтыг цаг тухай бүрт нь хийх
2. Ашиглагдаж буй нийт аппарат тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын зааварчилгаа болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан тарааж хэрэглээнд нь хяналт тавих



• Техникийн дүгнэлт, тооллого
1. Эвдрэлтэй тоног төхөөрөмжүүдэд эвдрэлийн шалтгаан, шаардлагатай сэлбэг хэрэгслийн талаар техникийн дүгнэлт гаргах
2. Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа тоног төхөөрөмжүүдийн актлах зэрэгт мэргэжлийн дүгнэлт гаргах



• Судалгаа
1. Тоног төхөөрөмжүүдийн дэлгэрэнгүй бүртгэл мэдээллийг ЭМЯ, ЭМХТ –ийн бүртгэлийн нэгдсэн санд нэмж оруулах
2. Албаны хэмжээнд тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтын талаар 8-12 төрлийн судалгаа гарган ашиглах, эмнэлгийн удирдлагыг шаардлагатай мэдээ, тоо баримтаар хангах
3. ЭМЯ болон ЭМХТ-ийг шаардлагатай судалгаа мэдээллээр хангах



• Төлөвлөлт
1. Тасаг нэгжүүдээс шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа авч нэгтгэх тэдгээрийн техникийн үзүүлэлтийг боловсруулах
2. Судалгааг үндэслэн цаашид шаардлагатай тоног төхөөрөмж төсөв төлөвлөгөө гарган шийдвэрлүүэх арга хэмжээ авах



• Захиалга

1. Шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг захиалах
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авалт зохион байгуулах
3. Тоног төхөөрөмжийн үнэ ханш, чанарын талаар удирдлагыг хэрэгцээт мэдээллээр хангах




• Хүчилтөрөгчийн хангамж

1. ҮОЭТ байгуулагдсанаар шинээр хүчилтөрөгчийн үйлдвэр 2019 оны 12-р сард ашиглалтанд орсон билээ. Ингэснээр хүчилтөрөгчийн хангамжийн үйл ажиллагаа чанарын шинэ төвшинд гарч хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа стандартын шаардлага бүрэн хангасан орчин бүрдсэн байна.



2. Хүчилтөрөгчийн үйлдвэр ашиглалтанд орсноор зөөврийн хүчилтөрөгчийн хэрэглээнд гарсан өөрчлөлт



Даралтат хийн шугам хоолой дараах байдлаар тоноглогдсон ба Хүүхдийн тасгийн хүчилтөрөгчийн хангамж зөөврийн баллоноор хийгддэг. Үүнд:

Хийн систем	Тасаг нэгжүүд
Хүчилтөрөгч	Төв байрны 3-4 давхар, Хүлээн авах , МЭЭТ болон 50 орт байрны эмчилгээний тасгууд ҮОЭТ
Нүүрс хүчлийн хий	Төв байр, 50 орт байрны хагалгааны хэсгүүд, ҮОЭТ
Агаар	МЭЭТ, Төв байр, 50 орт байрны хагалгааны хэсгүүд, ҮОЭТ

Introduction of activities to improve the use of medical equipment

D.Purevdorj[1], D.Алтансоёмбо[2], O.Tetuulen[3], D.Уганзаяа[4], Д.Nyamsuren[4]
G.Minkhtulga[5], E.Хишигбаатар[5], О.Ичинноров[5], Б.Тетишjin[6]

[1]Imaging, CT service, Equipment operation department, Second State Central Hospital
[2]Surgery I and II, EOD, SSCH
[3]Intensive Care Unit, EOD, SSCH
[4]Neurology, Gastroenterology, Cardiology, Special department, Outpatient, EOD, SSCH
[5]Central Laboratory, EOD, SSCH
[6]Oxygen, Disinfection, Washing, Rehabilitation, Pharmacy EOD, SSCH

Abstract: The activities of our department are aimed at ensuring the reliable and uninterrupted operation of the diagnostic, treatment, laboratory medical equipment and oxygen plant used in the hospital. As of the first half of 2020, 721 units of 152 types of medical equipment, 110 units of 22 types of non-medical equipment, and more than 8,000 units of tools are used in Second State Central Hospital.

Keywords: Improving the use of medical equipment and facilities